

Шоо

Багш 6 талд шооны талууд дээр цэгүүд ямар байрлалтай байдлыг бага насны хүүхдүүдээр 3 × 3 хэмжээтэй хүснэгтэд тэмдэглүүлжээ. Хүүхдүүд янз бүрээр тэмдэглэсэн байна. Эндээс багш зөв тэмдэглэснийг шалгах шаардлага гарав. Маш олон тэмдэглэгээ байсан тул програм зохиож ашиглахаар болов. Та програмыг нь зохиож өгнө үү.

Оролт. Гурван мөрөнд 3 тэмдэгт хоосон зайгүй байрлана. "o" нь цэг байгааг ":" нь цэг байхгүйг илэрхийлнэ.

Гаралт. Зөв тэмдэглэсэн бол цэгийн тоог, буруу бол "unknown" үгийг хэвлэ.

Жишээ

Оролт 1

o:o

:o:

o:o

Гаралт 1

5

Оролт 2

::o

:o:

o::

Гаралт 2

3

Оролт 3

ooo

:::

o:o

Гаралт 3

unknown